

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн лаборатори 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/49/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="mailto:www.govisumber@audit.gov.mn">www.govisumber@audit.gov.mn</a> ЧОЙР ХОТ 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:baranbayarg@audit.gov.mn">baranbayarg@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:batsaikhan@audit.gov.mn">batsaikhan@audit.gov.mn</a></p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс аудит ХХК Утас: 77270808: Цахим хаяг: <a href="mailto:nitsbalance@gmail.com">nitsbalance@gmail.com</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/.....	6
2.3 Аудит цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .....	15
3.6.3 Нэмэлт төсөв .....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа байхгүй.....	17
4.2 Төлбөрийн акт байхгүй.....	17
4.3 Албан шаардлага .....	17
4.4. Зөвлөмж .....	17
2. Засгийн газрын тогтоолтой холбоотой асуудал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 5-Р СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ О.ОДГЭРЭЛ ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын лаборатори сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын лаборатори 5-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Түрээсийн номны орлогыг мөнгөөр төвлөрүүлэн шилжүүлсэн боловч санхүүгийн үр дүнгийн тайланд ном, хэвлэлийн зардлаар тайлагнасан;
- Бараа материалын дансад үндсэн хөрөнгийн шинж чанартай 4,361.7 мянган төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн;
- Урсгал засварын зардлаас 3,237.0, бараа үйлчилгэний төлбөр хураамжийн зардлаас 2,839.8, бараа материалын зардлаас 9,234.1 мянган төгрөгөөр тус тус үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлд дотуур байрны гадна тохижилтын ажил нэртэй 116,588.9, спортын заалны шал солив нэртэй 23,800.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг тоолж бүртгэсэн.

Эдгээр зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, НББОУС 8-ын 10.Б.1-д: “аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх”, Төсвийн тухай хуулийн 16.5.5-батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцээгүй, “Ангилал” “ажил гүйлгээ, үйл явдлыг зөв дансанд ангилж бүртгэсэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГОВСУМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫНГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>216,758,104.22</b>	<b>240,048,480.44</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>2,156,886.01</b>	<b>2,711,081.78</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,156,886.01	2,711,081.78
31210	Төгрөг	2,156,886.01	2,711,081.78
31216	Ахмадын сан	2,156,886.01	2,711,081.78
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>552,006.83</b>	<b>1,553,373.20</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	552,006.83	1,553,373.20
33103	ХАОАТ-ын авлага	552,006.83	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>214,049,211.38</b>	<b>235,784,025.46</b>
35100	Түүхий эд материал	1,316,369.00	26,475,297.81
35110	Тусгай зориулалттай материал	0.00	25,794,407.81
35130	Эм боох материал	1,316,369.00	680,890.00
35400	Хангамжийн материал	212,732,842.38	209,308,727.65
35410	Бичиг хэргийн материал	1,392,780.00	2,467,052.00
35420	Аж ахуйн материал	146,103,950.78	130,716,507.06
35440	Түлш, шатах тослох материал	20,000.00	1,466,200.00
35460	Хүнсний материал	3,735,430.00	10,018,985.00
35470	Бусад хангамжийн материал	61,480,681.60	64,639,983.59
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>2,865,797,122.04</b>	<b>2,813,934,947.96</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,865,797,122.04</b>	<b>2,813,934,947.96</b>
39200	Биет хөрөнгө	2,547,523,288.53	2,495,833,447.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,745,067,707.63	2,511,587,545.63
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(431,796,205.64)	(263,174,545.07)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	295,368,518.65	360,221,364.74
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(165,064,787.27)	(215,780,761.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	144,152,762.08	174,660,596.62
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(40,478,874.15)	(71,685,752.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,025,000.00	4,025,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(3,750,832.77)	(4,019,999.45)
39300	Биет бус хөрөнгө	318,273,833.51	318,101,500.00
39301	Програм хангамж	1,070,000.00	1,070,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(700,166.49)	(872,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	317,904,000.00	317,904,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>3,082,555,226.26</b>	<b>3,053,983,428.40</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	<b>649,814.23</b>	<b>1,477,843.03</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>649,814.23</b>	<b>1,477,843.03</b>
41300	Өглөг	649,814.23	1,477,843.03

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	1,477,843.03
41311	Цалингийн өглөг	0.00	643,557.10
41313	ХАОАТ-ын өглөг	0.00	834,285.93
41360	Бусад өглөг	649,814.23	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	649,814.23	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>3,081,905,412.03</b>	<b>3,052,505,585.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,081,905,412.03</b>	<b>3,052,505,585.37</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,431,180,360.62	1,431,180,360.62
51200	Хуримтлагдсан үр дүн	1,401,492,953.82	1,372,093,127.16
51210	Өмнөх үеийн үр дүн	1,383,150,843.32	1,314,317,497.31
51220	Тайлант үеийн үр дүн	18,342,110.50	57,775,629.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	249,232,097.59	249,232,097.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>3,082,555,226.26</b>	<b>3,053,983,428.40</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,794,907,359.72</b>	<b>1,908,640,872.48</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>176,211,759.72</b>	<b>165,991,272.48</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	176,211,759.72	165,991,272.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,156,886.01	2,674,195.77
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	2,156,886.01	2,674,195.77
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	123,328,948.40	154,171,618.63
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	50,725,925.31	9,145,458.08
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,618,695,600.00</b>	<b>1,742,649,600.00</b>
1310	Улсын төсвөөс	1,432,371,400.00	1,509,973,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,432,371,400.00	1,509,973,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,871,500.00	35,394,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	5,811,500.00	35,394,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,060,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	178,452,700.00	197,282,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	178,452,700.00	197,282,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>1,773,770,048.65</b>	<b>1,850,865,242.63</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,773,770,048.65</b>	<b>1,850,865,242.63</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,702,990,027.63	1,829,854,699.52
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,183,062,481.01	1,239,121,257.45
210101	Үндсэн цалин	1,183,062,481.01	1,239,121,257.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,298,642.59	161,863,854.98
210201	Тэтгэврийн даатгал	102,102,092.59	113,319,397.79

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	12,004,861.00	12,569,686.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,519,889.00	9,948,218.19
210204	Ажилгүйдлийн даатгал	2,242,138.00	2,361,869.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,429,662.00	23,664,684.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,380,710.98	194,003,056.89
210301	Гэрэл, цахилгаан	7,596,728.98	8,164,838.49
210302	Түлш, халаалт	144,995,204.60	151,128,374.00
210303	Цэвэр, бохир ус	17,788,777.40	34,709,844.40
2104	Хангамж, бараа материалын зардал	25,294,847.76	12,102,520.00
210401	Бичиг хэрэг	3,130,270.00	2,038,230.00
210402	Тээвэр, шатахуун	460,000.00	585,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,000.00	738,298.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,262,080.00	7,506,591.00
210408	Бараа материал актласны зардал	12,102,497.76	994,401.00
2105	Нормативт зардал	25,924,996.30	54,145,174.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	498,356.00	1,562,479.00
210502	Хоол, хүнс	25,372,240.30	52,582,695.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	54,400.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	510,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	510,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,324,300.00	3,844,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	664,300.00	1,124,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	2,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,194,048.99	164,774,836.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,120,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	884,000.00	5,150,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	146,310,048.99	157,504,836.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,780,021.02	21,010,543.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,851,100.00	16,074,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,585,500.00	10,337,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,265,600.00	5,737,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,811,500.00	4,894,100.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,811,500.00	4,894,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,735,489.02	41,943.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,735,489.02	41,943.11
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,381,932.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,381,932.00	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)</b>	<b>21,137,311.07</b>	<b>57,775,629.85</b>
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,795,200.57</b>	<b>0.00</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	2,795,200.57	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,795,200.57	0.00

6	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>18,342,110.50</b>	<b>57,775,629.85</b>
---	--	----------------------	----------------------

### 2.3 Аудит цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,431,180,360.62</b>	<b>249,232,097.59</b>	<b>1,401,492,953.82</b>	<b>3,081,905,412.03</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(87,175,456.51)	(87,175,456.51)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,431,180,360.62	249,232,097.59	1,314,317,497.31	2,994,729,955.52
5	<b>Тайлант үеийн үр дүн</b>			<b>57,775,629.85</b>	<b>57,775,629.85</b>
6	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,431,180,360.62</b>	<b>249,232,097.59</b>	<b>1,372,093,127.16</b>	<b>3,052,505,585.37</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,620,852,486.01</b>	<b>1,745,323,795.77</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,156,886.01</b>	<b>2,674,195.77</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	2,156,886.01	2,674,195.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,156,886.01	2,674,195.77
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	2,156,886.01	2,674,195.77
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,618,695,600.00</b>	<b>1,742,649,600.00</b>
1310	Улсын төсвөөс	1,432,371,400.00	1,509,973,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,432,371,400.00	1,509,973,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,871,500.00	35,394,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	5,811,500.00	35,394,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,060,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	178,452,700.00	197,282,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	178,452,700.00	197,282,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>1,616,635,600.00</b>	<b>1,706,123,100.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,616,635,600.00</b>	<b>1,706,123,100.00</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,551,064,278.98	1,658,955,256.89
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,180,274,600.00	1,272,050,800.00
210101	Үндсэн цалин	676,615,508.00	1,000,810,900.00
210102	Нэмэгдэл	334,163,058.00	234,631,500.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	12,034,000.00	1,449,700.00
210104	Урамшуулал	157,462,034.00	35,158,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,364,400.00	129,107,500.00
210201	Тэтгэврийн даатгал	104,740,400.00	114,070,000.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	11,406,000.00	3,989,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,124,900.00	2,982,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,281,000.00	794,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,812,100.00	7,271,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,380,710.98	194,003,056.89
210301	Гэрэл, цахилгаан	7,596,728.98	8,164,838.49
210302	Түлш, халаалт	144,995,204.60	151,128,374.00
210303	Цэвэр, бохир ус	17,788,777.40	34,709,844.40
2104	Хангамж, бараа материалын зардал	16,731,500.00	15,709,600.00
210401	Бичиг хэрэг	2,012,200.00	1,125,500.00
210402	Тээвэр, шатахуун	480,000.00	2,031,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,000.00	782,700.00
210404	Ном, хэвлэл	6,111,500.00	5,304,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	246,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,747,800.00	6,219,000.00
2105	Нормативт зардал	18,882,868.00	29,850,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	720,000.00	850,000.00
210502	Хоол, хүнс	16,857,268.00	28,264,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,305,600.00	735,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,336,500.00	3,750,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		513,500.00
210604	Урсгал засвар	5,336,500.00	3,237,000.00
2107	Томиллолт, зочны зардал	510,000.00	
210702	Дотоод албан томиллолт	510,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,424,300.00	4,374,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	764,300.00	1,654,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	2,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,159,400.00	10,109,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,120,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	6,159,400.00	7,989,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,571,321.02	47,167,843.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,453,900.00	47,125,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,133,100.00	40,938,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,320,800.00	6,187,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,735,489.02	41,943.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,735,489.02	41,943.11
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,381,932.00	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,381,932.00	

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>4,216,886.01</b>	<b>39,200,695.77</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,060,000.00</b>	<b>38,646,500.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,060,000.00</b>	<b>38,646,500.00</b>
223	БУСАД ХӨРӨНГӨ	2,060,000.00	38,646,500.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,060,000.00	38,646,500.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>	<b>(2,060,000.00)</b>	<b>(38,646,500.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	<b>2,156,886.01</b>	<b>554,195.77</b>
14	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>2,156,886.01</b>
15	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,156,886.01</b>	<b>2,711,081.78</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,707,255,500.00</b>	<b>1,707,255,500.00</b>		<b>100.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,707,255,500.00</b>	<b>1,707,213,556.89</b>	41,943.11	100.0
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,660,579,600.00</b>	<b>1,660,537,656.89</b>	41,943.11	99.9
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,272,050,800.00</b>	<b>1,272,050,800.00</b>		<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	1,000,810,900.00	1,000,810,900.00		100.0
210102	Нэмэгдэл	232,649,900.00	234,631,500.00	(1,981,600.00)	100.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,431,300.00	1,449,700.00	1,981,600.00	42.2
210104	Урамшуулал	35,158,700.00	35,158,700.00		100.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх</b>	<b>129,107,500.00</b>	<b>129,107,500.00</b>		<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	114,070,000.00	114,070,000.00		100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,989,200.00	3,989,200.00		100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,982,000.00	2,982,000.00		100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	794,900.00	794,900.00		100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,271,400.00	7,271,400.00		100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>194,045,000.00</b>	<b>194,003,056.89</b>	41,943.11	99.9
210301	Гэрэл, цахилгаан	8,500,000.00	8,164,838.49	335,161.51	96.0
210302	Түлш, халаалт	149,845,000.00	151,128,374.00	(1,283,374.00)	100.8
210303	Цэвэр, бохир ус	35,700,000.00	34,709,844.40	990,155.60	97.2
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,475,500.00</b>	<b>6,475,500.00</b>		<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	835,500.00	835,500.00		100.0
210402	Тээвэр, шатахуун	1,031,700.00	1,031,700.00		100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	824,700.00	782,700.00	42,000.00	94.9

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	368,400.00	410,400.00	(42,000.00)	111.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	246,700.00	246,700.00		100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,168,500.00	3,168,500.00		100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>29,240,000.00</b>	<b>29,240,000.00</b>		<b>100.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	240,000.00	240,000.00		100.0
210502	Хоол, хүнс	28,264,800.00	28,264,800.00		100.0
210503	Нормын хувцас, зөөлөн	735,200.00	735,200.00		100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,737,000.00</b>	<b>22,737,000.00</b>		<b>100.0</b>
210601	Багаж, техник хэрэгсэл	19,500,000.00	19,500,000.00		100.0
210604	Урсгал засвар	3,237,000.00	3,237,000.00		100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>				
210702	Дотоод албан томилолт				
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний</b>	<b>4,374,000.00</b>	<b>4,374,000.00</b>		<b>100.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,654,000.00	1,654,000.00		100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00		100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,549,800.00</b>	<b>2,549,800.00</b>		<b>100.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,549,800.00	2,549,800.00		100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>46,675,900.00</b>	<b>46,675,900.00</b>		<b>100.0</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,938,400.00	40,938,400.00		100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,737,500.00	5,737,500.00		100.0
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		41,943.11	(41,943.11)	
<b>3</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>1,707,255,500.00</b>	<b>(1,707,255,500.00)</b>	
<b>31</b>	<b>Улсын төсвөөс санхүүжих</b>		<b>1,509,973,500.00</b>	<b>(1,509,973,500.00)</b>	
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		1,509,973,500.00	(1,509,973,500.00)	
320001	Орон нутгийн төсвөөс		197,282,000.00	(197,282,000.00)	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын лаборатори 5-р сургуулийн /цаашид ерөнхий боловсролын лаборатори 5-р сургууль гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Засгийн газрын тогтоол хэрэгжилт, авлага, өглөгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр 2022 оны “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн ахлах аудитор Ц.Энхтуяа, захирал Ш.Ичинхорлоо нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, дараагийн шатны чанарын хяналтыг төрийн аудитын газрын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлэв.

Ерөнхий боловсролын лаборатори 5-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Эн Ай Ти Эс Баланс Аудит ХХК-д хянуулахаар 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Ерөнхий боловсролын лаборатори 5-р сургуулийн үйл ажиллагааны эрхэм “Хүүхдийн сурах үйлийг дэмжих сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргах, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дараах зорилго, зорилтын хүрээнд тус сургууль нь Улс, аймаг орон нутагт онцлог бүхий үр дүнтэй ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнд:

- Өндөржүүлсэн бэлэн байдлын үед теле хичээлээс гадна 223 цахим хичээл бэлтгэж, 187 цахим даалгавар боловсруулан хүүхэд нэг бүрийн хоцрогдолгүй сургахад анхаарсан
- Зэрэгтэй багш нарын үзүүлэх хичээлийг 26 багш зааж, 34 Зэрэгтэй, залуу багш хамтран 16 цагийн хичээл зааж туршлага хуримтлуулсан
- Багш нарыг чадваржуулах үндсэн сургалтанд 12 багш орон нутгийн сургалтанд давхардсан тоогоор 25 удаагийн сургалтанд 421 багш, ажлын байран дээрх 8 удаагийн сургалтанд 287 багш хамрагдаж мэргэжлээ тасралтгүй дээшлүүлсэн.
- Элсэлтийн нэгдсэн шалгалтаар Аймагтаа тэргүүлсэн, 8 хичээлээр элсэлтийн шалгалт өгүүлж тус 8 хичээлээрээ Улсын дунджаас дээгүүр үнэлүүлсэн.
- Олон улсын Эко ногоон сургуулийн хөтөлбөрт хамрагдаж Олон улсын Эко Ногоон сургууль “Мөнгөн гэрэгэ”-ний болзол хангасан. Тогтвортой хөгжлийн боловсрол Олон улсын цахим хичээлд Улсад 2, 10, тусгай байруудад багш нарын бэлтгэсэн 3 хичээл шалгарч түгээн дэлгэрүүлэлт хийгдсэн зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”.

- Боловсрол, шинжлэх Ухааны Сайд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайд, Сангийн Сайдын хамтарсан тушаал 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дугаар А/35/А/10/9.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны бүртгэл, тайлагналын онцлог, холбогдох шаардлагыг хангаж байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөнхий боловсролын лаборатори 5-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу санхүүгийн тайлан бэлтгэж, тайлагнасан байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх баталсан төсвийн нийт зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх баталсан төсвийн нийт зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэл 1,707,213.5 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 17,072.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 12,804.1 мянган төгрөгөөр тогтоов.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлын суурь үзүүлэлтийн дүн жилийн төсвийн гүйцэтгэлийн их биш зөрүүтэй байгаа тул аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Ерөнхий боловсролын лаборатори 5-р сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,571.8 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт хөрөнгө өмнөх оноос буурсан нь үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	2,156.9	2,711.1	554.2
Авлага	552.0	1,553.4	1,001.4
Бараа материал	214,049.3	235,784.0	21,734.7
Үндсэн хөрөнгө	2,865,797.1	2,813,934.9	(51,862.2)
Богино хугацаат өр төлбөр	649.8	1,477.8	827.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,081,905.4	3,052,505.6	(29,399.8)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,082,555.2</b>	<b>3,053,983.4</b>	<b>(28,571.8)</b>

Авлага дансны үлдэгдэл 1,001.4 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбоотой авлага, үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 21,734.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Хандиваар 9,145.5 мянга, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 77,814.8 мянган төгрөгийн бараа материалыг ххудалдан авч бүртгэсэн, өмнөх оны үлдэгдлээс зарцуулагдаагүй зэргээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 51,862.2 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн тайлант оны өөрчлөлтөөс шалтгаалсан байна. Тухайлбал, Өөр өөр нэрээр давхар бүртгэлтэй байсан спорт заалны барилгын 330,937.6 мянган төгрөгийн үнийг залруулж хассан бол тайлант онд худалдан авсан 38,646.5 мянга, хандив болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 154,171.6 мянга, нийт 192,8181 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,447.8 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбоотой өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо данс өмнөх оноос 29,399.8 мянган буурсан нь үндсэн хөрөнгийн бууралттай холбоотой байна.

Ерөнхий боловсролын лаборатори 5-р сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 113,733.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант оны орлого нэмэгдэхэд дараах орлогуудын өөрчлөлтүүд нөлөөлжээ. Үүнд:

- Өөрийн орлого 517.3 мянга;
- Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 86,602.1 мянга;
- Нэмэлт санхүүжилтийн орлого 27,522.6 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардал өмнөх оноос 77,095.2 мянган төгрөг өссөн байна. Тайлант онд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 69,624.1, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 23,622.4 мянга, нормотивт зардал 28,220.2 мянга, бараа үйлчилгээний зардал 17,577.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ерөнхий боловсролын лаборатори 5-р сургуулийн 2021 оны төсөв 1,707,255.5 мянган төгрөгөөр баталснаас 1,509,973.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 197,282.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 4 зориулалт арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,707,255.5 мянган төгрөгийг баталж, зарцуулжээ.

Тайлант оны улс, орон нутгийн төсвийн санхүүжилтийг бүрэн авч, үйл ажиллагааны зардалд 100.0 хувь зарцуулсан байна.

Баталсан нийт төсөвт зардлыг 100.0 хувиар зарцуулж, Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу үйл ажиллагааны зарим зардлын хэмнэлтийг бий болгож ажиллаагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 35,394.1 мянга төгрөгийн орлогыг олгосныг бүрэн зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Гүйцэтгэлийн гэрээний зорилтын хүрээнд хийгдэх 43 арга хэмжээ, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд 9 арга хэмжээ, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээ, өмнөх оны төлөвлөгөөнөөс биелээгүй цаашид үргэлжлүүлэн хийх шаардлагатай 1 арга хэмжээ нийт 5 чиглэлээр 57 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Гэрээгээр 1 дүгээр арга хэмжээ 93%-тай, 2 дугаар арга хэмжээ 91,6%-тай, 3 дугаар арга хэмжээ 92,5%-тай, 5 дугаар арга хэмжээ 100%-тай биелэгдсэн. Нийт гүйцэтгэлийн хувь 94,2%-тай биелэгдсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, стандарт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй тул санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т “хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1,

6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүмбэр сумын 5 дугаар сургууль 2021 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 149 мэдээллийг байршуулахаас 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Сүмбэр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн тайлант оны үйл ажиллагаанд 1,707,255.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, гүйцэтгэлээр 1,707,255.5 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсөвт зардлыг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн баталсан төсвийн зарцуулалт нь Засгийн газрын тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1 төлбөрийн акт, 5 зөвлөмж өгсөн ба 1 төлбөрийн акт, 4 зөвлөмж нь хэрэгжиж, Шилэн дансны нэгдсэн цахим хуудастай холбоотой 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйгээс тайланд онд давтагдсан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх, их хэмжээний буюу 235,784.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийн шалтгаан, үр дагаврыг тодруулах гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, бараа материалын нөөц, үлдэгдлийн шалтгааныг нарийвчлан тогтоох нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 313,022.6 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 140,388.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 172,633.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн, залруулагдаагүй 312,952.6 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс 300,148.6 мянган төгрөгөөр их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### **4.1 Залруулсан алдаа байхгүй**

#### **4.2 Төлбөрийн акт байхгүй**

#### **4.3 Албан шаардлага**

**4.3.1.** \_Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлд дотуур байрны гадна тохижилтын ажил нэртэй 116,588.9 мянга, спортын заалны шал солив нэртэй 23,800.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг тоолж бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэнтэй нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Холбогдох үндсэн хөрөнгүүдийн засварын засварын зардлын дүнгээр капиталжуулан анхны өртгийг нэмэгдүүлэн бүртгэх.

#### **4.4. Зөвлөмж**

##### **1. Авлага, өглөгтэй холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 1,553.4 мянган төгрөгийн авлага, ХХОАТ-ын 824.3 мянган төгрөгийн өглөгийг тус тус барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахдаа дээд шатны байгууллагаар дамжуулан Санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан байгууллагын шийдвэр болон дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх.

##### **2. Засгийн газрын тогтоолтой холбоотой асуудал**

##### 2.1.Илрүүлэлт:

Сүмбэр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь тайлант оны үйл ажиллагааны зардлыг 100.0 хувь зарцуулж, батлагдсан төсөвт зардлын 10.0 буюу 170,256.0 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: "...батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэнтэй нийцэхгүй байна.

2.2.Өгсөн зөвлөмж: Засгийн газрын шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллах..

##### **3. Дотоод хяналттай холбоотой**

**3.1** Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулбал зохих 149 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ. 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэсэнтэй нийцэхгүй байна.

**3.2** Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх ажиллах. Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1.1	Үндсэн хөрөнгийн дансанд дотуур байрны гадна тохижилт болон спортын заалны шал солив гэсэн нэртэй хөрөнгүүдийг бүртгэсэн.	1	140,388.9							1	140,388.9		
1.2	Тайлант оны 1,553.4 мянган төгрөгийн авлага, ХХОАТ-ын 824.3 мянган төгрөгийн өглөгийг тус тус барагдуулаагүй	1	2,377.7									1	2,377.7
2	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
2.1	Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулбал зохих 149 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	0,0									1	
1.2	Тайлант оны үйл ажиллагааны зардлыг 100.0 хувь зарцуулж, батлагдсан төсөвт зардлыг хэмнээгүй байна.	1	170,256.0									1	170,256.0
НИЙТ ДҮН		4	313,022.6							1	140,388.9	3	172,633.7

